



**ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН**

2024

ЖИЛИЙН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

ЭРХЭМ ХҮНДЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА

Монголын хамгийн анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сан нь Монгол улсын төрийн өмчит компаниудын хувьчлалд оролцож өгөөж ашгаа хөрөнгө оруулагчдадаа өгөх эрхэм зорилгынхоо хүрээнд хөрөнгө оруулалтын бодлого стратегиа хэрхэн хэрэгжүүлсэн талаар энэхүү тайлангаар харуулахыг зорилоо.

2024 он нь олон улсын санхүүгийн зах зээлд өндөр хувьсал, тодорхойгүй байдал давамгайлсан онцгой жил байлаа. Дэлхийн хэмжээнд төв банкнуудын мөнгөний хатуу бодлого, геополитикийн хурцадмал нөхцөл байдал, инфляцын түвшин, эдийн засгийн өсөлтийн удаашрал зэрэг хүчин зүйлс нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад ихээхэн нөлөөлөв. Түүнчлэн, зах зээлийн мэдрэмж өндөртэй хөрөнгө оруулагчид хувьцааны үнэлгээ, эрсдэлийн удирдлагыг шинэ өнцгөөс харж эхэлсэн нь олон улсын сангуудын бүтэц, хөрөнгө оруулалтын чиглэлийг дахин тодорхойлоход хүргэлээ. Монгол Улсын хувьд 2024 онд уул уурхайн салбарын идэвхжил, түүхий эдийн экспортын өсөлт эдийн засгийн өсөлтийг дэмжсэн эерэг үзүүлэлтүүдийн нэг байсан хэдий ч инфляц, төгрөгийн ханшийн тогтворгүй байдал, хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны үнэлгээний савлагаа зэрэг нь дотоодын хөрөнгө оруулагчдад эрсдэл дагуулсан хэвээр байна. Манай сан эзэмшиж буй зарим хувьцааны үнэ богино хугацаанд бууралттай байсан ч, компанийн үндсэн үнэ цэнэ, санхүүгийн үзүүлэлтүүд нь дунд болон урт хугацаанд үнэ өсөх бодит боломж байгааг харуулж байгаа тул бид богино хугацааны хэлбэлзлээс илүүтэйгээр үнэ цэнийн хөрөнгө оруулалтад төвлөрсөөр байна.

Ирэх 2025 оны хувьд Монголын хөрөнгийн зах зээл шинэ шатанд гарч, шинэ хөрөнгө оруулалтын боломжуудыг нээх нөхцөл бүрдэх төлөвтэй байна. Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдыг татахын тулд ил тод, тогтвортой, хуулийн орчныг сайжруулсан бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнийг дагаад Монголын Хөрөнгийн Биржид шинэ төрлийн санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэх, зах зээлийн оролцогчдын боловсрол, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах нь чухал ач холбогдолтой. Бид энэхүү шинэчлэлийн давуу талуудыг бүрэн ашиглан, хөрөнгө оруулагчдадаа урт хугацааны өгөөж бий болгох стратегийг цаашид ч баримтлан ажиллах болно.

Сангийн менежер

У.Сүхдарь

ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС (MSE:ХОС) нь 2020 оны 10 дугаар сард үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 5 жилийн хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд цар тахал, томоохон геополитикийн асуудлууд үүсэж улс орнуудын эдийн засаг, хөрөнгийн зах зээлийг ихээхэн уналтад оруулсан хэдий ч манай хамт олон тухай бүрд хөрөнгө оруулалтын зохистой шийдвэр гаргаж чадсанаар сангийн цэвэр хөрөнгийн дүн ₮5 тэрбумаас ₮6.75 тэрбумд хүрч 35%-ийн өсөлтийг үзүүлж чадсан байна. 2024 онд нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ ₮135.10 хүрч оны эхнээс 7.2% өссөн байна. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 35%-иар өсөөд байна.
- 2024 оны эхний хагас жилд бид Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй Монголын Хөрөнгийн Бирж ХК (MSE:MSE), Түмэн Шувуут ХК (MSE:TUM), Премиум Нэксус ХК (MSE:CUMN), Инновэйшн инвестмент ХК зэрэг компаниудын хувьцааг худалдан авахдаа Growth at a Reasonable Price (GARP) буюу өсөлттэй хувьцааг боломжийн үнээр авах хөрөнгө оруулалтын стратеги ашигласан. Энэ стратеги нь бага ханштай хувьцаа худалдан авч, өндөр өгөөжийг бодитойгоор үзүүлэх боломжийг бидэнд олгосон юм. 2024 он бидний хөрөнгө оруулалтын урт хугацааны стратеги зөв байсныг дахин баталсан жил байлаа. Мөн нэгж эрх эзэмшигчид маань арилжааны томоохон банкнууд болох Хаан Банк ХК (MSE:KHAN), Хас Банк ХК (MSE:ХАС) болон Голомт Банк ХК (MSE:GLMT) зэрэг компаниудын хувьцаа эзэмшигчид болоод байгаа юм.
- Сангийн зүгээс үнэ цэнэ, өсөлт хосолсон хувьцааны багцыг цаашид ч өргөжүүлж, хөрөнгө оруулагчдынхаа урт хугацааны ашигт ажиллагааг дээд түвшинд хадгалахын төлөө ажиллах болно.

Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт

	2020	2021	2022	2023	2024
Үндэсний Хувьчлалын Сангийн өгөөж	25.6%	91.2%	-24.4%	-10.63%	7.21%
ТОП-20-ийн өгөөж	-1.7%	130%	-15.4%	10.31%	23.79%
Хадгаламжийн хүү	11.3%	~9%	10.3%	12.00%	11.77%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТОВЧ ГҮЙЦЭТГЭЛ

Тикэр
ХОС

Гаргасан нэгж эрх
50 сая ширхэг

Нэгж эрх эзэмшигчийн тоо
6,882

Нэгж эрхийн хаалтын ханш
₮114.94

Зах зээлийн үнэлгээ
₮5.74 тэрбум

Жилийн арилжааны эргэлт
₮566.1 сая

Нэгж эрхийн NAV
₮135.10

Нийт цэвэр хөрөнгө NAV
₮6.75 тэрбум

ТУЗ ГИШҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Батбилэгийн Золбоо

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн дарга**

Мэргэжил: Санхүү, эдийн засаг

Албан тушаал: “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн
Гүйцэтгэх захирал, “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн
ТУЗ-ийн дарга



Галбадрахын Цогбадрах

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүн**

Мэргэжил: Эдийн засагч, санхүүч

Албан тушаал: “Ард Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн
гишүүн, Гүйцэтгэх захирал, “Ард Менежмент ҮЦК”
ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Чулуунбаатарын Хандаа

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүн**

Мэргэжил: Эдийн засагч

Албан тушаал: ТУЗ-ийн ердийн гишүүн



Пүрэвийн Баянсан

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХХК-ийн ТУЗ-
ийн хараат бус гишүүн**

Мэргэжил: Бизнесийн удирдлага

Албан тушаал: , МУИС, Санхүүгийн тэнхимийн
ахлах багш



Батхүү Ариунболд

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүн**

Мэргэжил: Санхүү, эдийн засаг

Албан тушаал: “Интергрупп Интернэйшнл ХХК”
Санхүү эрхэлсэн захирал

“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн баг “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах зэрэг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилладаг.



Угтахбаяр Сүхдарь

Мэргэжил: Санхүү, Хөрөнгө оруулалт

Албан тушаал: “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн
сангийн менежер

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны шинэчилсэн журмын дагуу Сангийн нийт хөрөнгийн 80-аас доошгүй хувиар дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж ажилладаг. Ингэхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалт хийдэг билээ.


НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2023 оны эцсийн байдлаар Үндэсний Хувьчлалын Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тоо 6,153 байсан бол оны 2024 онд 6,882-д хүрч 11.8%-иар өссөн байна. Нэгж эрх эзэмшигчдийн тоо тогтвортойгоор өсөж байгааг харвал сангийн үйл ажиллагаа хэвийн байгаа болон хөрөнгө оруулалтын сангийн эрэлт хэрэгцээ буураагүй байгааг харж болж байна.

Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
АРД ДААТГАЛ ХК	5,658,294	11.3%
ТУЛГА	2,999,610	6.0%
АРДЫН ТЭТГЭВРИЙН ДАНС	2,847,851	5.7%
АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК	2,500,000	5.0%
М СИ ЭС ИНВЕСТМЕНТ	2,500,000	5.0%
АРД КРЕДИТ ББСБ	1,558,998	3.1%
БОГД БАНК	1,371,500	2.7%
МАНДАХБАЯР	1,000,000	2.0%
НАРАНБАТ	1,000,000	2.0%
ЦЭРЭНДОЛГОР	807,141	1.6%
Бусад 6,872	27,756,606	55.5%
Нийт	50,000,000	100.00%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ


ХОС нь 2024 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийж ажиллаа. Цэвэр хөрөнгийн үнэлгээ 2024 онд 6.75 тэрбум төгрөгт хүрч 7.2%-иар, зах зээлийн үнэлгээ нь 5.74 тэрбум төгрөгт хүрч 8.0%-иар тус тус өссөн байна. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 35.0%-иар өссөд байна.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


	Зах зээлийн ханш	NAV(Цэвэр хөрөнгийн үнэ)
12/31/2024	114.94	135.10
Оны эхнээс %	8.00%	7.21%
Сан нээгдсэнээс хойш	14.90%	35.10%
2024 оны доод дээд	80.05-117.89	112.99-135.10

Тайлант хугацааны туршид сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Тайлант хугацааны эцэс дэх сангийн хөрөнгийн задаргаа (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

ХОС-ийн хувьд хөрөнгө оруулалтын бодлого болон зохицуулагч байгууллагын тогтоосон харьцаа үзүүлэлтийг өртгийн аргаар тооцсон хувь хэмжээгээр тооцдог бөгөөд харьцаа үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангаж байгаа болно. Багцын дахин тэнцвэржүүлэлтийг богино хугацааны давтамжтай хийх нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегитай харшилддаг тул бид өртгийн аргаар тооцож харьцаа үзүүлэлтийг хангаж ажилладаг билээ. Шалтгаан нь бид багцад байгаа өсөлттэй хувьцааны хувийн жинг бууруулахгүй байх, уналттай хувьцааны хувийн жинг өсгөхгүй байх нь хөрөнгө оруулалтын зөв бодлого гэж үздэгт оршино.

ХОС нь Монголын Хөрөнгийн Бирж дээрх нээлттэй компанийн хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийдэг ба багцын дийлэнх буюу 80 орчим хувийг дангаар бүрдүүлж байна. Тайлант хугацаанд гадаад дотоодын нөхцөл байдлаас шалтгаалан дотоод болон гадаадын тодорхой хувьцаануудаа зарж гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой хувьцаануудаар багцаа сэлгэн хөрөнгө оруулалтууд хийж ажиллаа.

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ХОС-ийн хувьцааны багцад нийт 31 хувьцаа байгаа бөгөөд үүнээс 25 нь дотоодын хувьцаа, 6 нь гадаад хувьцаа байна. Салбараар нь харвал санхүүгийн 11, өргөн хэрэглээний 5, түүхий эдийн 5, аж үйлдвэрийн 3 тогтмол бус хэрэглээний 3, технологийн 3, харилцаа холбооны салбарын 1 хувьцаануудаас багц бүрджээ.

Хувьцааны багц, эдийн засгийн салбараар (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар, нийт хөрөнгийн багцад эзлэх хэмжээ %)



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

САНГИЙН ЗАРДАЛ

Тайлан хугацаанд сангийн нийт хөрөнгийн өдрийн дундаж үлдэгдэл нь 6,107 сая төгрөг байсан бөгөөд зардлын нийт дүн нь 210.2 сая төгрөг болсон байна. Нийт хөрөнгийн үнэлгээнээс тооцсон нийт зардлын харьцаа нь 2024 онд 3.13% байна.

Зардлын задаргаа(Сая төгрөгөөр)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

САНГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тайлант хугацааны эцэст зах зээлийн үнэлгээгээр тооцвол багцын 88%-ийг эрсдэл өндөртэй хөрөнгө буюу хувьцаа эзэлж байгаа бол үлдсэн хэмжээг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий хөрөнгүүд эзэлж байна.

Сангийн өдөр бүрийн цэвэр хөрөнгийн үнэлгээний (NAV) тоо мэдээнд тулгуурлан шинжилж үзвэл, эрсдэлийн үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

Өдрийн NAV хөдөлгөөний тархалт



Mean	0.000351873
Standard Error	0.000356498
Median	0
Mode	0
Standard Deviation	1.15%
Sample Variance	0.000131666
Kurtosis	5.853418064
Skewness	0.946687668
Range	0.12642932
Minimum	-0.053319189
Maximum	0.073110131
Sum	0.364540168
Count	1036

Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээний 1,036 өдрийн мэдээлэлд тулгуурлан эрсдэлийн үзүүлэлтийг тооцоолбол дээрх байдалтай байна.


Хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээний өдрийн стандарт хазайлт нь өндөр байх тусам хөрөнгө оруулагчид өндөр эрсдэл хүлээж байгааг илэрхийлдэг. Олон улсад өдрийн стандарт хазайлтыг 2%-с дээш байвал эрсдэл өндөр, 1%-с бага байвал эрсдэл бага гэж үздэг бөгөөд Хөрөнгө оруулагч үндэстэн сангийн хувьд өдрийн стандарт хазайлт 1.15% байна.

НОГДОЛ АШИГ ТАРААХГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭР

Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 25/01 тоот тогтоолоор “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогод заасны дагуу 2024 оны цэвэр ашгаас нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэр гаргалаа. ТУЗ нь ХОС-ийн нэгж эрх танилцуулга болон хөрөнгө оруулалтын бодлогын дагуу ногдол ашиг тараахгүй гэж шийдсэн болно.

НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

Үндэсний Хувьчлалын Сан нь хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан буюу гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй сан юм. Хөрөнгө оруулагчид нэгж эрхээ Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан өөр хоорондоо арилжаалах боломжтой байдаг бөгөөд сангийн хөрвөх чадвар сайн байх нь зах зээлийн ханш зөв тогтох үндэс болдог. ХОС-ийн нэгж эрхийн арилжааны эргэлт 2024 онд ₮566.2 сая байгаа ба нийт 6.09 сая ширхэг нэгж эрх арилжаалагдсан ба энэ нь сангийн 12.18 хувь гар сэлгэсэн байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ТАЙЛАН

Ард Менежмент ҮЦК ХХК (цаашид “Ард Менежмент” гэх) нь өндөр өгөөжтэй, ирээдүйд хурдтай өсөх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, удирдах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Ард Менежмент нь 2011 онд үүсгэн байгуулагдаж, 2016 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авснаар хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх болсон.

Ард Менежмент нь 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдөр ХОС-той байгуулсан №20/14 тоот Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулж байна.

2024 онд Ард Менежментээс ХОС-д гэрээний дагуу үзүүлсэн ажил үйлчилгээг тоймлон харуулвал:

Хөрөнгө итгэмжлэн удирдах

- ХОС-ийн хувьд 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар 6.75 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгийн үнэлгээтэйгээр (NAV нь нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийг хассан дүн) хаагдсан ба энэ оны эхнээс 7.21 хувийн өсөлттэй байсан бол үүсгэн байгуулагдсан цагаас хойш 35.1 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.
- Хөрөнгө оруулалтын багцыг удирдах. ХОС-ийн хувьд 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар 41 сая төгрөгийн хүүгийн орлого, 167 сая төгрөгийн ногдол ашгийн орлого тус тус олсон
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-н шийдвэрээр гүйцэтгэж байна.

ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

- ХОС-ийн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хадгалах, хуульд заасан хугацаанд холбогдох төрийн байгууллагуудад санхүүгийн тайланг гаргаж хүргүүлэв.
- ХОС-ийн тайлан мэдээнүүдийг гаргаж, тайлагнахтай холбоотой Голомт Банкны кастодиан банкны газар, МХБ, СЗХ-той хамтран ажиллаж, МХБ болон Ард Менежментийн цахим сайтуудад Сангийн нэгж эрхийн арилжаа, хөрөнгө оруулалтын талаар тогтмол мэдээг хүргэв.
- ХОС-ийн багц дахь хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн арилжааны захиалга хийх, төлбөр тооцоо төлөх, кастодиантай мэдээлэл солилцох ажлыг тогтмол гүйцэтгэж байна.
- Сангийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай журам, заавар гаргаж, түүнийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

САНГИЙН МЕНЕЖЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үндэсний Хувьчлалын Сан болон Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн У.Сүхдарь нь хөрөнгө оруулалтын сантай холбоотой хууль, дүрэм, журмын хүрээнд сангийн хөрөнгийг удирдаж, өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллаа. Үндэсний Хувьчлалын Сангийн хувьд хөрөнгө оруулалтын багцыг удирдах, сангийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Нийт 2,264.6 сая төгрөгийн нийт 1,653 хэлцэл хийгдсэн ба 21 хувьцаагаар дамжуулан хийлээ.

Сангийн менежерийн үндсэн ажлыг хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны гэж хоёр хувааж авч үзэж болох бөгөөд дараах ажлууд тогтмол болон тухай бүр хийгдсэн байна.


Сангийн хөрөнгийн удирдлагатай холбоотой ажлууд:

- Хөрөнгө оруулалтын багцыг удирдах. ХОС нь урт хугацааны хөрөнгө оруулалтууд хийдэг ба хэтэрхий өндөр үнэлэгдсэн тодорхой хэдэн хувьцаануудаас гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой дунд хугацааны хөрөнгө оруулалтууд хийж ажиллаа.
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-н шийдвэрээр гүйцэтгэх.

Сангийн үйл ажиллагаатай холбоотой ажлууд:

- Сангийн үнэ ханшийн мэдээллийг өдөр бүр олон нийтэд хүргэх.
- Улирал бүр ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Улирал бүр Earning Call хийж сангийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банкинд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- Сангийн хагас жилийн болон бүтэн жилийн тайланг бэлтгэж олон нийт болон зохицуулах байгууллагад хүргүүлэх.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх.

ГОЛОМТ КАСТОДИАНЫ ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2024 ОНЫ ТАЙЛАН



Хөрөнгө хадгалах үйлчилгээ

2024 онд "Үндэсний хувьчлалын сан хамтын ХОС"-ийн нийт удирдаж буй хөрөнгө өмнөх оноос 5.5%-иар өссөн байгаа ба багцыг нийт үнэлгээ 6.7 тэрбум төгрөгт хүрч, 6,882 нэгж эрх эзэмшигчийн 50 сая сангийн нэгж эрхийг зах зээл нийлүүлээд байна.



MISSION

The genesis of Prosperity

VISION

Mongolia's Global Benchmark Bank


ГОЛОМТ КАСТОДИАНЫ ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2024 ОНЫ ТАЙЛАН

Кастодиан банк | ГОЛОМТ БАНК



Хадгалж буй хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээ

"Үндэсний хувьчлалын сан хамтын ХОС"-гийн нийт удирдаж буй хөрөнгө 2024 оны эцсээр 6.7 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байгаа ба нийт хөрөнгийн 88.83%-ийг хувьцаа, 11.38%-ийг бэлэн мөнгө болон хадгаламжинд байршуулаад байна.



Кастодиан банк | ГОЛОМТ БАНК



Нэгж эрхийн тухайлсан бүртгэл

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-д "хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг тухайн санд үйлчилгээ үзүүлж байгаа кастодиан хөтөлнө" гэж заасан байдаг. "Үндэсний хувьчлалын сан хамтын ХОС"-н хөрөнгийг хадгалдаг кастодианы хувиар дээр дурьдсан гэрээний хүрээнд Голомт банк нь нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлөх үйлчилгээг үзүүлж байна. 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нэгж эрх эзэмшигчдын бүртгэл дараах байдлаар байна.

	Харилцагчийн тоо	Нэгж эрхийн тоо ширхэг		Хөрөнгийн үнэлгээ	
		2023	2024	2023	2024
Нэгж эрх эзэмшигч					
Иргэн	6143	6864	33,102,273	31,234,934	4,222,007,698
Байгууллага	20	18	16,897,727	18,765,066	2,155,209,507
Нийт	6163	6882	50,000,000	50,000,000	6,377,217,204
					6,728,024,208

ГОЛОМТ КАСТОДИАНЫ ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2024 ОНЫ ТАЙЛАН

Нэгж эрхийн цэвэр үнэлгээ


"Үндэсний хувьчлалын сан хамтын ХОС"-ын нэгж эрхийн үнэлгээ нь тухайн сангийн вэб хуудас болон аппликэйшнээр дамжуулан олон нийтэд мэдээлэгддэг бол кастодиан банкнаас цэвэр үнэлгээнд давхар тооцоолол баталгаажуулан тухай бүр тулган хамтран ажилладаг.



Хөрөнгө оруулалтын менежментийн компанитай тухай бүр үнэлгээний тулгалтыг кастодиан банк хийх бөгөөд Сангийн нэгж эрхийн цэвэр үнэлгээг тооцоход хөрөнгө оруулалтын хэрэгслийн бүртгэл, зах зээлийн үнэлгээний өөрчлөлт зэрэг тухай бүр тооцогддог.

Кастодиан банк нь 2024 онд нэгж эрхийн цэвэр үнэлгээ өдөр алгасангүй (365) тооцоолж санд хүргүүлсэн байна. Өдөр бүр сангийн хөрөнгийн бүхий л түвшинд тулган баталгаажуулж хамтран ажиллаж байна.

Нэгж эрхийн цэвэр үнэлгээ 134.56 хүрсэн ба өмнө оноос 6.79 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.



MISSION

The genesis of Prosperity

VISION

Mongolia's Global Benchmark Bank

Кастодиан банк | ГОЛОМТ БАНК

Төлбөр тооцоо

2024 онд кастодиан банк нь дараах төлбөр тооцоо бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

- Мөнгөн хөрөнгийн 421 сая.төгрөг бүхий 83 удаагийн гүйлгээ болон хадгаламжийн 256 сая.төгрөг бүхий 22 удаагийн гүйлгээ гараас гүйцэтгэв.

Сар	Мөнгөн дүн	Сар	Мөнгөн дүн
1		7	19,840.00
2	79,423,961.64	8	5,204,500.00
3	3,072,303.50	9	1,016,800.00
4	191,338,932.49	10	12,714,429.22
5	90,911,980.44	11	12,697,829.22
6	12,714,029.22	12	12,698,329.22
Нийт		421,812,934.95	

Сар	Мөнгөн дүн	Сар	Мөнгөн дүн
1	0.00	7	17,000.01
2	78,977,205.48	8	83,709,249.22
3	2,464,200.00	9	2,000.00
4	2,000.00	10	9,604,399.00
5	105,923,726.03	11	0.00
6	0.00	12	0.00
Нийт		256,518,580.72	

ГОЛОМТ КАСТОДИАНЫ ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2024 ОНЫ ТАЙЛАН

Кастодиан банк | ГОЛОМТ БАНК



Компанийн үйл ажиллагаа

Харилцагчийн үнэт цаастай нь холбогдон гарах бүх төрлийн компанийн үйл ажиллагааг түргэн шуурхай мэдээлэх ба харилцагчаас ирүүлсэн зааврын дагуу компанийн үйл ажиллагаанд төлөөлөн оролцож холбогдох эрхүүдийг хэрэгжүүлдэг.

- 2024 онд дараах үйлчилгээг үзүүлэв.

Эзэмшиж буй 26 компаний хувьцаа эзэмшигчдийн хурлын бусад холбогдох мэдээллийг хүргүүлж, гадаад хувьцааны 5 удаагын ногдол ашгийн төлөлт, дотоодын компаний хувьцааны 22 удаагын 164 сая төгрөгийн ногдол ашгийн төлөлтийг харилцагчийн дансанд байршуулсан.

Тайлан мэдээлэл / Тулгалт /

Сангийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг ХОМК-с өдөр бүр гүйлгээний даалгавар, нэгтгэсэн кастодианы зааварчилгааг хүлээн авч тухай бүр бүртгэл, гүйлгээг хийж, цэвэр хөрөнгийн үнэлгээнд зөрүү үүсэх эрсдлээс урдчилан сэргийлж, хөрөнгийн бүртгэлийг зөрүүгүй хийж гүйцэтгэхээр бүртгэлийн ажлыг зохион байгуулж байна.

Кастодианы бүртгэлийн системээс дараах тайлан харилцагч ХОС-д автоматаар тухай бүр гарч харилцагчдад мэдээлэл хүргүүлдэг.

- | | |
|-------------------------------------|--|
| • Хөрөнгө оруулалтын багцын тайлан | Багцад байгаа санхүүгийн хэрэгсэл бүрээр хөрөнгийн хэмжээг харах боломжтой. |
| • Арилжааны тайлан | Үнэт цаасны арилжааны дэлгэрэнгүй тайлан |
| • Гүйлгээний тайлан | Үнэт цаасны гүйлгээ, бүртгэлийн дэлгэрэнгүй тайлан |
| • Нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл | Нэгж эрх эзэмшигч бүрийн мэдээлэл, эзэмшиж буй нэгж эрхийн хэмжээ, |
| • Цэвэр хөрөнгийн үнэлгээний тайлан | Санхүүгийн хэрэгслэл бүр дэх үнэт цаас бүрийн тоо ширхэг, худалдан авсан үнэ, зах зээлийн үнэ г.м. |
| • Дансны дэлгэрэнгүй хуулга | Тухайн сард гасан хөрөнгийн өөрчлөлт, хийгдсэн гүйлгээний мэдээлэл |

КАСТОДИАН БАНКНЫ ХЭЛТЭС

ГОЛОМТ БАНК

2024 он



MISSION

The genesis of Prosperity

VISION

Mongolia's Global Benchmark Bank

2024

Жилийн
тайлан

MSE:XOC

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Нийт хөрөнгийн хувьд 6,800 сая төгрөгийн хөрөнгөтэй, цэвэр хөрөнгө 6,755 сая төгрөгт хүрсэн бөгөөд 2023 оны мөн үетэй харьцуулахад хөрөнгө 6.23%, цэвэр хөрөнгийн дүн 5.95%-ийн өсөлтийг тус тус үзүүлсэн байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Сая төгрөг

Үзүүлэлт	2023 Q4	2024 Q4
Нийт хөрөнгө	6,402	6,800
Мөнгө	550	619
Санхүүгийн хөрөнгө /Бодит/	5,832	6,152
Авлага	7	16
Хойшлогдсон татварын хөрөнгө	13	13
Нийт өр төлбөр	26	45
Дансны өглөг	14	33
Хойшлогдсон татварын өр	12	12
Эздийн өмчийн дүн	6,375	6,755
Өмч	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг	1,375	1,755

ОРЛОГЫН ТАЙЛАН

Сая төгрөг

Үзүүлэлт	2023 Q4	2024 Q4
Хүүгийн орлого	127	41
Ногдол ашгийн орлого	66	167
Бодит үнэ цэнийн өсөлтийн олз	(726)	428
Нийт ашиг (алдагдал)	(533)	636
ХОМК-ийн үйлчилгээний зардал	(155)	(153)
Кастодианы үйлчилгээний зардал	(22)	(23)
Бусад зардал	(61)	(77)
Нийт үйл ажиллагааны зардал	(238)	(253)
Татварын өмнөх ашиг	(771)	383
Хойшлогдсон татварын зардал	(22)	(3)
Тайлант үеийн цэвэр ашиг	(793)	380

САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД ХИЙСЭН ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“Үндэсний хувьчлалын сан хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид “Үндэсний хувьчлалын сан хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК (цаашид “Компани” гэх)–ийн 2024 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн орлогын дэлгэрэнгүй тайлаДн, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

АОУС–ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангуудын (үүнд тодруулгууд багтана) ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН ХАМТЫН ХОС ХХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

<i>Мянган төгрөгөөр</i>	Тод	2024-12-31	2023-12-31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	15	5,972,651	5,656,944
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	15	180,000	175,000
Дансны болон бусад авлага	16	15,938	7,346
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	17	619,222	549,749
Эргэлтийн хөрөнгө		6,787,811	6,389,039
Эргэлтийн бус хөрөнгө			
Хойшлогдсон татварын хөрөнгө		12,806	12,806
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		12,806	12,806
Нийт хөрөнгө		6,800,617	6,401,845
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Бусад өглөг	19	33,174	14,050
Орлогын татварын өглөг		12,372	12,372
Нийт богино хугацаат өр төлбөр		45,546	26,422
Урт хугацаат өр төлбөр			
Хойшлогдсон татварын өглөг		-	-
Нийт урт хугацаат өр төлбөр		-	-
Нийт өр төлбөр		45,546	26,422
ЦЭВЭР ХӨРӨНГӨ			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	18	5,000,000	5,000,000
Хуримтлагдсан ашиг		1,755,071	1,375,423
Нийт цэвэр хөрөнгө		6,755,071	6,375,423
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө		6,800,617	6,401,845

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН ХАМТЫН ХОС ХХК

2024 ОНЫ 12 САРЫН 31-НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН

АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

<i>Мянган төгрөгөөр</i>	Тод	2024	2023
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	8	22,169	109,336
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	8	19,268	17,299
Ногдол ашгийн орлого	9	167,187	65,685
Бусад орлого		-	638
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бусад цэвэр өөрчлөлт		246,493	(799,682)
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз / (гарз)	10	193,487	75,390
Гадаад валютын ханшийн зөрүүгийн цэвэр олз	11	(12,242)	(1,914)
Нийт орлого/ (Зардал)		636,362	(533,248)
ХОМК-ийн үйлчилгээний зардал	12	(152,832)	(154,601)
Кастодианы үйлчилгээний зардал	12	(23,364)	(21,628)
Бусад зардал	13	(77,449)	(61,223)
Нийт үйл ажиллагааны зардал		(253,645)	(237,452)
Татварын өмнөх ашиг / (алдагдал)		382,717	(770,700)
Орлогын албан татварын зардал	14	(3,069)	(22,318)
Тайлант жилийн ашиг		379,648	(793,018)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (төгрөгөөр)		7.59	(15.86)

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Сүүлийн 30 жилийн хугацаанд Монгол Улс ардчилсан нийгэмд шилжиж, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээ гурав дахин нэмэгдүүлсэн нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал дэвшил болоод байна. 2024 оны байдлаар Монгол Улс ядуурлыг бууруулах чиглэлд ахиц гаргаж, дундаас дээш орлоготой орны ангилалд багтаад байна. Гэсэн хэдий ч илүү олон, чанартай ажлын байр бий болгох асуудал тулгамдсаар байна.

Хөдөлмөрийн зах зээлд залуучууд болон эмэгтэйчүүдийг оролцуулах нь сорилт хэвээр байсаар байгаа юм. Монгол улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлт хоёр дахь жилдээ макро-санхүүгийн эерэг үр дүнг үзүүлж байгаа боловч энэ нь уул уурхайн салбараас хэт хамааралтай болж байгааг тодотгож, эдийн засгийн төрөлжилт хийх зайлшгүй шаардлагыг сануулж байгааг илтгэж нүүрсэнд суурилсан эдийн засгийн өсөлт нь уур амьсгалын өөрчлөлт болон хөгжлийн сорилтуудыг улам даамжруулж байгаа тул бүтцийн өөрчлөлт хийх шаардлага амин чухал болоод байна. Энэ бүхэн нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангаж, Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн тогтвортой байдлыг баталгаажуулахад чиглэсэн бодлогын шинэчлэлийг нэн даруй хийх шаардлагатайг харуулж байгаа юм.

	2023	2024T	2025T	2026T
ОУВС	7.0	5.5	7.0	6.0
Дэлхийн Банк	7.0	5.3	6.3	6.3
АХБ	7.0	5.5	6.0	N/A
Монгол Улсын нэгдсэн төсөв	7.0	5.6	8.0	6.5
Европын сэргээн босголт, хөгжлийн банк	7.0	5.0	8.0	N/A
Монголбанк	7.0	5.5	7.3	4.9
Судлаачийн тооцоолол	7.0	5.1	6.1	5.6

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2024 онд нүүрсний экспортын өсөлтөөр үргэлжлэн тогтвортой байсан ч 2023 оны 7.0 хувиас буурч 4.9 хувьд хүрсэн. Харин 2025-2026 онд эдийн засгийн өсөлт жилд дунджаар 6.3 хувьд хүрэх төлөвтэй бөгөөд энэ нь ялангуяа Оюутолгой уурхайгаас гарч буй зэсийн олборлолт зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн огцом өсөлтөөс шалтгаалах хүлээлттэй байна.

Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС, АХБ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Ковид-19 цар тахлаас хойш худалдаа, үйлчилгээний салбар идэвхжиж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа бол хөдөө аж ахуйн салбарын уналт нь өсөлтийг хязгаарласан хэвээр байна. Нүүрс, төмрийн хүдэр болон зэсийн баяжмалын үйлдвэрлэл* нэмэгдсэнээр уул уурхайн салбар 2024 оны байдлаар 10.84 хувиар, тээврийн салбар 23.1 хувиар тус тус тэллээ. Өрхийн бодит орлого нэмэгдэж, эдийн засаг дахь худалдан авалтын идэвх нэмэгдсэнээр бөөний болон жижиглэн худалдааны салбар 6.5 хувиар өсөж, үйлчилгээний салбарын идэвх сайжрав.

Монгол Улсын ДНБ-ын өсөлтийн бүтэц, салбаруудаар / 2020-2024 /

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Эдийн засгийн өсөлт	-4.6%	1.6%	4.8%	7.4%	4.9%
Хөдөө аж ахуй	0.8%	-0.8%	1.7%	-1.3%	-3.6%
Үйлдвэрлэл	-1.3%	-0.6%	-0.8%	3.2%	1.7%
Уул уурхай	-1.4%	0.1%	-1.6%	2.6%	1.4%
Боловсруулах	0.3%	-0.1%	0.5%	0.4%	-0.1%
Цахилгаан	0.0%	0.2%	0.1%	0.1%	0.1%
Барилга	-0.1%	-0.9%	0.2%	0.1%	0.3%
Үйлчилгээ	-3.0%	1.8%	2.6%	4.7%	4.8%
Худалдаа	-1.4%	0.6%	0.9%	0.8%	0.8%
Тээвэр	-1.0%	-0.3%	0.1%	1.8%	1.4%
Мэдээлэл, холбоо	0.1%	0.5%	0.2%	0.5%	0.5%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	-0.7%	1.1%	1.4%	1.7%	2.2%
Цэвэр татвар	-1.1%	1.3%	1.4%	0.8%	2.0%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Сүүлийн 4 жилд бий болсон эдийн засгийн өсөлтийг бий болгож буй салбар тус бүрээр нь ангилан харвал 2024 оны байдлаар 4.9% ийн өсөлтийн дийлэнх хэсгийг үйлчилгээний салбар 2.2%, үйлдвэрлэлийн салбар 1.7%, уул уурхайн салбар 1.4% тус тус нөлөөлсөн бол хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн өсөлтийг 3.6% иар бууруулсан байна.

* - 2024 оны байдлаар нүүрс үйлдвэрлэл 100.1 сая тоннд хүрч, өмнөх оноос 23 хувиар, төмрийн хүдэр, баяжмал үйлдвэрлэл 6.6 сая тоннд хүрч, өмнө оны мөн үеэс 24 хувиар, зэсийн баяжмал үйлдвэрлэл 1.6 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар тус тус өссөн байна. Харин алт үйлдвэрлэл 12.6 тонн, газрын тос үйлдвэрлэл 4.2 сая баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 15 болон 14 хувиар тус тус буураад байна.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


Монгол Улс 2024 онд нийт 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд үүнээс экспорт 15.8 тэрбум ам.доллар, импорт 11.6 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 12.1% буюу 3 тэрбум ам.доллар, экспорт 3.9% буюу 596.5 сая ам.доллар, импорт 25.5% буюу 2.4 тэрбум ам.доллаароор тус тус өсөж тэнцэл 1.8 тэрбум ам.доллаароор буурсан байна.

Экспорт 2024 онд өмнөх оноос 596.5 сая ам.доллаароор өсөхөд зэсийн хүдэр баяжмал 693.4 сая ам.доллар, алт 161.4 сая ам.доллар, төмрийн хүдэр, баяжмал 152.8 сая ам.доллаароор тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импорт өмнөх оноос 2.4 тэрбум доллароор өсөхөд суудлын автомашин 395.6 сая ам.доллар, ачааны автомашин 288.6 сая ам.доллар, дизелийн түлш 186 сая ам.доллаароор тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум доллар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2024 онд нийт 250 удаагийн үнэт цаасны арилжаагаар 1.4 их наяд төгрөгийн арилжаа хийгдэж нийт арилжааны дүн өмнөх оноос 2 дахин, хоёрдогч зах зээлийн арилжаа 2.3 дахин, анхдагч зах арилжаа 1.7 дахин өссөн байна.

МХБ арилжааг арилжааны төрлөөр авч үзвэл нийт арилжааны 25 хувийг хувьцааны арилжаа, 1 хувийг хөрөнгө оруулалтын сангийн арилжаа, 74 хувийг бонд, хбүц-ийн арилжаа бүрдүүлж байна.


Сарын дундаж хоёрдогч арилжааны дүн 46 тэрбум төгрөг болж арилжааны идэвх сэргэсэн.

Зах зээлийн үнэлгээ түүхэн дээд түвшиндээ хүрч өмнөх оноос 27 хувь өслөө.

Энэ жил өрийн хэрэгслийн хувьд онцлох жил боллоо.Тухайлбал нийт 85 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 732 тэрбум төгрөгийн нээлттэй бонд шинээр гарсан бөгөөд мөн биржийн бус зах зээл дээр 953 тэрбум төгрөгийн, 22 сая долларыг татан төвлөрүүлээд байна.

Улаанбаатар үнэт цаасны бирж дээр 2024 онд нийт тэрбум 22 тэрбум төгрөгийн арилжаа явагдаж мөн анхны өрийн хэрэгсэл бүртгэгдлээ.

МХБ-н арилжаа /2021-2024/ тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2024 ОНЫ ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2024 онд дэлхийн зах зээл технологи, ногоон эрчим хүчний салбаруудын өсөлтөөр тодорхойлогдож, инфляц буурч, хөгжиж буй зах зээлүүдийн гүйцэтгэл хүчтэй байж, томоохон IPO-ууд болон геополитикийн эрсдэлүүдээр онцлог жил боллоо. Тодруулбал:

Хувьцааны зах зээлүүдийн гүйцэтгэл:

- S&P 500: Энэхүү индекс 2024 онд нийт 23.31%-ийн өсөлт үзүүлж, технологи болон бараа бүтээгдэхүүний салбарын хүчтэй гүйцэтгэл үзүүлэв.
- NASDAQ Composite: NASDAQ 28.64%-ийн өсөлттэй байж, 19,310.79 хүрсэн нь технологийн салбарын өсөлтөөр онцгойрч чадлаа.
- Dow Jones Industrial Average: Dow 12.88%-ийн өсөлт үзүүлж, аж үйлдвэр болон санхүүгийн салбарын дэмжлэгтэйгээр тогтвортой өсөлттэй байв.
- Nikkei 225: 2024 онд онцгой амжилт үзүүлж, жилийн 19.22%-ийн өсөлттэйгээр сүүлийн арван жилийн доторх хоёр дахь хамгийн өндөр гүйцэтгэлийг үзүүлэв. Энэхүү индекс 7-р сарын 11-нд 42,426.77 хүрч түүхэн дээд амжилт тогтоосон ба энэ нь томоохон компаниудын ашгийн үзүүлэлт болон таатай мөнгөний бодлоготой холбоотой байв.
- Hang Seng индекс 2024 онд хүчтэй сэргэлт үзүүлж, дараалсан дөрвөн жилийн алдагдлын дараа жилийн 17.7%-ийн өсөлттэй байв. Энэ нь оны эцэст 20,059.95 хүрч хаагдсан бөгөөд технологийн салбарын 16.60% сэргэлт, төрийн өмчит компаниудын 23.18% өсөлт хүчтэй нөлөөлөв.



Эх сурвалж: Yahoo Finance

2024 оны салбарын үзүүлэлтүүд:

Технологи: Салбаруудын хамгийн өндөр өсөлт бөгөөд технологийн компаниуд, ялангуяа хиймэл оюун ухаан (AI), үүлэн технологи, хагас дамжуулагч салбарын компаниудын хүчтэй гүйцэтгэлээс үүдэлтэй.

Харилцаа холбоо: Харилцаа холбооны компаниуд, тэр дундаа 5G технологийн хөгжүүлэлт болон үүлэн үйлчилгээний компанийн амжилт нөлөөлжээ.

Санхүү: Санхүүгийн технологи болон хөрөнгө оруулалтын сангийн компаниудын өндөр үзүүлэлттэй холбоотой байна.

Хэрэглээний бараа бүтээгдэхүүн: Хэрэглэгчийн худалдан авалт нэмэгдэж, цахим худалдаа, хэрэглээний барааны эрэлт өндөр байлаа.

Үйлчилгээ: Аялал жуулчлал, зочид буудал, фитнес үйлчилгээ зэрэг салбарууд эргэн сэргэж, эрэлт өссөн.

Аж үйлдвэр: Үйлдвэрлэлийн шинэ техник, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн автоматжуулалт нэмэгдсэн.

Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн: Хүнсний бүтээгдэхүүн болон өдөр тутмын хэрэглээний барааны эрэлт сайн байлаа.

Эрчим хүч: Сэргээгдэх эрчим хүчний салбарын өсөлт болон эрчим хүчний үнэ өссөн нь эрчим хүчний компаниудын гүйцэтгэлд нөлөөлсөн.

Үл хөдлөх: Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн өсөлт бага, зарим бүс нутагт үл хөдлөхийн үнэ буурсантай холбоотой байна.

Эрүүл мэнд: Өрсөлдөөнтэй салбар бөгөөд зохицуулалт, өндөр эмийн үнийн дарамт зэрэг хүчин зүйлс нь сөргөөр нөлөөлжээ.

Суурь материал: Барилгын салбарын уналт, суурь материалын үнэ буурсан нь энэ салбарт сөргөөр нөлөөлсөн.



Эх сурвалж: Finviz

2025 оны төлөв:

2025 оны OECD-ийн гаргасан дэлхийн эдийн засгийн төсөөллөөр улс орнуудын инфляцын эсрэг тэмцэл голлох зорилго байх бөгөөд хэрэв зорилгодоо хүрч чадвал төв банкнуудын бодлого хүний нөөцийн асуудалд чиглэнэ гэж үзэж байгаа юм. Ажилгүйдлийн түвшин хэдийгээр өндөр биш ч, олон оронд ажлын хүчинд оролцох хувь харьцангуй бага байгаа нь эдийн засгийн хүндрэлийг авчирч байгаа учир бодлогын чиглэлийг хэмнэхээс илүүтэйгээр ажил эрхлэлт нэмэгдүүлэхэд чиглүүлэх аж.

Түүнчлэн, дэлхийн эдийн засагт өндөр өр, төсвийн алдагдал хэвээр байх бөгөөд энэ нь бүхий л улс орнуудын санхүүгийн чадавхад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Дэлхийн нийт засгийн газрын өр \$100 триллион хүрсэн бөгөөд энэ хэмжээ нь эдийн засгийн өсөлтийн хурдацтай өсөлттэй уялдаатай байна.

Эдийн засгийн төсөөлөл	Дундаж	2023	2024	2025	2026
	2013-2019				
Хувь					
Real GDP growth					
World	3.4	3.2	3.2	3.3	3.3
G20	3.5	3.6	3.3	3.3	3.2
OECD	2.3	1.8	1.7	1.9	1.9
United States	2.5	2.9	2.8	2.4	2.1
Euro area	1.9	0.5	0.8	1.3	1.5
Japan	0.8	1.7	-0.3	1.5	0.6
Non-OECD	4.4	4.4	4.4	4.4	4.3
China	6.8	5.2	4.9	4.7	4.4
India	6.8	8.2	6.8	6.9	6.8
Brazil	-0.4	2.9	3.2	2.3	1.9
OECD unemployment rate	6.5	4.8	4.9	4.9	4.8
Inflation					
G20	3.0	6.1	5.4	3.5	2.9
OECD	1.7	7.1	5.4	3.8	3.0
United States	1.3	3.8	2.5	2.1	2.0
Euro area	0.9	5.4	2.4	2.1	2.0
Japan	0.9	3.3	2.6	1.9	2.1
World real trade growth	3.4	1.0	3.5	3.6	3.5

Анхаарал хандуулах салбарууд:

Хиймэл Оюун Ухаан ба Технологи: Хиймэл оюун ухаан, квант компьютер болон бусад шинэчлэлтүүд нь дэлхий даяар технологийн салбарын өсөлтийг дараагийн түвшинд хүргэхээр байна.

Ногоон Эрчим Хүчний Шилжилт: Сэргээгдэх эрчим хүч, цахилгаан автомашинууд болон нүүрснээс хамаарахгүй технологиудын хөрөнгө оруулалт эрчимжиж, дэлхийн тогтвортой байдалд чиглэсэн зорилтуудтай нийцүүлэхээр байна.

Хэрэглэгчийн Зардал: Хөгжиж буй зах зээлүүдийн хэрэглэгчдийн өсөж буй тоо нь хэрэглээний бараа бүтээгдэхүүн, цахим үйлчилгээ болон санхүүгийн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлнэ.

ESG Хөрөнгө Оруулалт: Байгаль орчин, нийгмийн асуудал, засаглалын шалгуурт нийцсэн ESG хөрөнгө оруулалт үргэлжлэн дэлхийн хөрөнгө оруулалтын шийдвэрүүдийг удирдан чиглүүлэх төлөвтэй байна.

Эх сурвалж: OECD